

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/024/НА-СТА-ОНТС

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот  
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас:70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn  
Аудитор: Р.Аюуш  
Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
Асуудлыг онцолсон хэсэг .....	
Аудитын гол асуудал.....	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	
4.1 Ерөнхий зүйл.....	
4.2 Материаллаг байдал.....	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.5.1 Завсрын аудитын талаар .....	
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	
5.3 Албан шаардлага .....	
5.4 Зөвлөмж.....	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Э.НАСАНБАТ ТАНАА

2026.03.25 № УВА-2026/024/НА-СТА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр баталсан “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлд оруулах тухай” хуулийн 17 дугаар зүйлд “2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна. Үүнд: 15.Увс 10,770.9 сая төгрөг” гэж баталсан байхад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолын 6-д Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 10,780.9 сая төгрөгөөр, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн дансны 2025 оны урьд оны үлдэгдлийг 1,244.7 сая төгрөг байхад 68.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,313.6 сая төгрөгөөр тус тус батлуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь заалтад “Орон нутгийн төсвийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн хуульд нийцүүлэн алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ”, 57.3 дахь заалтад “Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна” гэж

8555050883

заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
  
9065555 1525010041

М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,244,744,451.82</b>	<b>168,284,198.82</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,244,744,451.82	168,284,198.82
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,244,744,451.82	168,284,198.82
31211	Төрийн сангийн харилцах	1,244,744,451.82	168,284,198.82
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,244,744,451.82</b>	<b>168,284,198.82</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,244,744,451.82</b>	<b>168,284,198.82</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,244,744,451.82</b>	<b>168,284,198.82</b>
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,244,744,451.82	168,284,198.82
51210	Өмнөх үеийн үр дүн	1,615,247,080.82	1,244,744,451.82
51220	Тайлант үеийн үр дүн	(370,502,629.00)	(1,076,460,253.00)
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,244,744,451.82</b>	<b>168,284,198.82</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,822,411,400.00</b>	<b>5,289,795,165.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>21,900,000.00</b>	<b>5,289,795,165.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	21,900,000.00	55,518,065.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,900,000.00	55,518,065.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,900,000.00	55,518,065.00
123	Улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	5,234,277,100.00
123002	Орон нутгийн хөгжлийн сангаас шилжүүлсэн орлого /УТ-ОН/	0.00	5,234,277,100.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,800,511,400.00</b>	<b>0.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>4,800,511,400.00</b>	<b>0.00</b>
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	4,800,511,400.00	0.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,822,411,400.00</b>	<b>5,289,795,165.00</b>
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,192,914,029.00</b>	<b>6,366,255,418.00</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	5,192,914,029.00	6,366,255,418.00
VII	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>(5,192,914,029.00)</b>	<b>(6,366,255,418.00)</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(370,502,629.00)</b>	<b>(1,076,460,253.00)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>4,822,411,400.00</b>	<b>4,822,411,400.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	21,900,000.00	55,518,065.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,900,000.00	55,518,065.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,900,000.00	55,518,065.00

123	Улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	5,234,277,100.00
123002	Орон нутгийн хөгжлийн сангаас шилжүүлсэн орлого /УТ-ОН/	0.00	5,234,277,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,800,511,400.00	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,800,511,400.00	0.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	4,800,511,400.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,822,411,400.00	5,289,795,165.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,192,914,029.00	6,366,255,418.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,192,914,029.00	6,366,255,418.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,192,914,029.00	6,366,255,418.00
223001	Бусад хөрөнгө	5,192,914,029.00	6,366,255,418.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,192,914,029.00)	(6,366,255,418.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(370,502,629.00)	(1,076,460,253.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,615,247,080.82	1,244,744,451.82
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,244,744,451.82	168,284,198.82

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/Төгрөг/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			1,615,247,080.82	1,615,247,080.82
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			1,615,247,080.82	1,615,247,080.82
C07	Тайлант үеийн үр дүн			(370,502,629.00)	(370,502,629.00)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			1,244,744,451.82	1,244,744,451.82
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			1,244,744,451.82	1,244,744,451.82
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			1,244,744,451.82	1,244,744,451.82
D08	Тайлант үеийн үр дүн			(1,076,460,253.00)	(1,076,460,253.00)
D09	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			168,284,198.82	168,284,198.82

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
1	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	100.00	5,289,795,165.00
12	Татварын бус орлого	100.00	5,289,795,165.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	55,518,065.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/	0.00	55,518,065.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	100.00	5,234,277,100.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	100.00	5,234,277,100.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,013,215,500.00</b>	<b>6,366,255,418.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,013,215,500.00</b>	<b>6,366,255,418.00</b>
223001	Бусад хөрөнгө	5,013,215,500.00	6,366,255,418.00
8	Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	(5,013,215,400.00)	(1,076,460,253.00)
9	<b>Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>5,013,215,400.00</b>	<b>1,076,460,253.00</b>
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	5,013,215,400.00	1,076,460,253.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,244,744,451.82
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	168,284,198.82

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэг. Орон нутгийн хөгжлийн сангийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

- Төсвийн тухай хууль,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай
- Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”

- Засгийн газрын 2023 оны 457 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”;
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд ороогүй байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтуудыг 2025.01.01-ээс мөрдөнө.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,076.4 сая төгрөгөөр буюу 86.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,244.7	168.3	(1,076.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,244.7</b>	<b>168.3</b>	<b>(1,076.4)</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,244.7	168.3	(1,076.4)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,244.7</b>	<b>168.3</b>	<b>(1,076.4)</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 168.3 сая төгрөг болж 1,076.4 сая төгрөгөөр буурсан нь төсөл арга хэмжээний санхүүжилтээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 168.3 сая төгрөг болж 1,076.4 сая төгрөгөөр буурсан нь тайланд үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,244.7 сая төгрөг болж, өмнөх оноос 370.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	1,244.7	168.3	(1,076.4)
Төрийн сангийн харилцах	1,244.7	168.3	(1,076.4)
<b>Дүн</b>	<b>1,244.7</b>	<b>168.3</b>	<b>(1,076.4)</b>

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 7,547.9 сая төгрөг, нийт зарлагыг 7,547.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж батлуулсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,120.0 сая төгрөгөөр бууруулан тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,234.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,323.6 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, нийт 6,547.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 5,234.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 55.5 сая, нийт 5,289.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,366.3 сая төгрөг буюу 97.2 хувьтай байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг урьд оны дансны үлдэгдэл 1,244.7 сая төгрөг байхад 1,313.6 сая төгрөг буюу 68.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөсөнд зөвлөмж өглөө.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Итгэлцүүрээр олгох – Бусад хөрөнгө /70106/83401/	6,547.9	6,366.3	181.6	97,2
	<b>Дүн</b>	<b>6,547.9</b>	<b>6,366.3</b>	<b>181.6</b>	<b>97,2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь орон нутгийн тусгай сан учраас нэмэлт төсөв байхгүй байна.

### 3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс дараах 1 арга хэмжээнд зарцуулалт гараагүй байна.

#### Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Батлагдсан төсөв	/сая төгрөгөөр/
				Гүйцэтгэл
1	Улаангом сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлыг эхлүүлэх	2025	300.0	0.00
	<b>ДҮН</b>		<b>300.0</b>	<b>0.00</b>

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 8/400 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,192.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 51.9 сая төгрөгөөс гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцож 41.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,366.3 сая төгрөгийн 1 хувиар буюу 63.7 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 50.9 сая төгрөгөөр тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хувьд тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Аймгийн төсвөөр 2025 оны жилд хэрэгжүүлэх их засвар, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтаар Гадаадын иргэн харьяатын газарт автомашины парк шинэчлэлд 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр

батлагдсан төсөл арга хэмжээг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр тендер худалдан авах ажиллагааг зарласан байна.

Мөн Аймгийн төсвөөр 2025 оны жилд хэрэгжүүлэх их засвар, хөрөнгө оруулалтаар тендер худалдан авах ажиллагааг зохион байгуулсан Гадаадын иргэн харьяатын газарт автомашины парк шинэчлэл төсөл, арга хэмжээгээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 18-ны 42 дугаар тогтоолоор өөрчлөн аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад шилжүүлэн баталж, гүйцэтгэлийг гаргасан зөрчилд зөвлөмж өглөө.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан төсөв, хөрөнгө зарцуулах, эрх шилүүлэх 5,915.1 сая төгрөгийн 27 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүйд албан шаардлага хүргүүлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорил хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 8.1-д "ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ" гэж заасныг зөрчиж аймгийн Засаг даргын 2025 оны А/666 дугаар захирамжаар аймгийн ОНХС-аас 763.5 сая төгрөгийг барилгын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлж Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үрд дүн, үр нөлөө гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүйд алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад Сангийн яамны ОНХС-ийн мэдээллийн <https://onhs.mof.gov.mn/> цахим системд оруулсан мэдээллийг хянаж үзэхэд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг оруулаагүй байсанд зөвлөмж өглөө.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,253.1 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 6/1065 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn систем бүртгэсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	6,253.1	1	6,253.1	100%
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>6,253.1</b>	<b>1</b>	<b>6,253.1</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант онд зарцуулаагүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдлийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс барьцаа данс руу шилжүүлсэн байна. Дараагийн аудитаар дээрх санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.
2. Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8.5-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно" гэж заасан байхад Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаал нь хүчингүй болсон байгааг холбогдох шатны газарт хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 13,305.4 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс 6,678.7 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 6,626.8 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өглөө.

#### 5.2 Албан шаардлага

##### Илрүүлэлт:1

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан төсөв, хөрөнгө зарцуулах, эрх шилжүүлэх 5,915.1 сая төгрөгийн 27 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим

хуудаст байршуулаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

#### **Илрүүлэлт:2**

Аймгийн ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 8.1-д "ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ" гэж заасныг зөрчиж аймгийн Засаг даргын 2025 оны А/666 дугаар захирамжаар аймгийн ОНХС-аас 763.5 сая төгрөгийг барилгын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлж Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үрд дүн, үр нөлөө гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.1-д заасныг мөрдөж ажиллах албан шаардлага өглөө.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой**

##### **1.1. Илрүүлэлт:**

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг урьд оны дансны үлдэгдэл 1,244.7 сая төгрөг байхад 1,313.6 сая төгрөг буюу 68.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь заалтад “Орон нутгийн төсвийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн хуульд нийцүүлэн алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ”, 57.3 дахь заалтад “Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Цаашид Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийг мөрдөн ажиллах.

#### **2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой**

##### **2.1. Илрүүлэлт:**

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдөр баталсан “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлд оруулах тухай” хуулийн 17 дугаар зүйлд 2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна. Үүнд: 15.Увс 10,770.9 сая төгрөг гэж баталсан байна.

Харин аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолын 6-д аймгийн 2025 оны Орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 10,780.9 сая төгрөгөөр буюу 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь заалтад “Орон нутгийн төсвийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн хуульд нийцүүлэн алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ”, 57.3 дахь заалтад “Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Цаашид тухайн онд батлагдсан Төсвийн тухай хуулийг мөрдөн ажиллах.

## **3. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой**

### **3.1. Илрүүлэлт:**

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 6,547.9 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээний мэдээллийг Сангийн яамны ОНХС-ийн мэдээллийн <https://onhs.mof.gov.mn/> цахим системд мэдээлээгүй байна.

Дээрх зөрчил Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “ил тод байдлыг хангасан байх”, 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 10.2-д “ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ”, 10.2.1-д “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна”, 10.2.3-д “Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь орон нутгийн төсвийн батлагдсан сар, улирлын хуваарьтай нийцүүлэн ОНХС-ийн сум, дүүргээр хуваарилан баталсан сар, улирлын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна”, 10.2.5-д “Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хуваарилагдан ирсэн орлогын шилжүүлгийг ажлын 2 өдөрт багтаан батлагдсан хуваарийн дагуу сум, дүүрэгтээ хуваарилж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ”, 10.3-д “Тухайн орон нутгийн төрийн сангийн төлбөр тооцоо, зарлага хариуцсан мэргэжилтэн нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ ОНХС-ийн УМС-ийг дараах байдлаар ашиглана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Цаашид Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор ирүүлж, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор, албан шаардлагын биелэлтийг 2027 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр /

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн ОНХС	1	68.9					1	68.9				
Аймгийн ОНХС	1	10.0					1	10.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>78.9</b>					<b>2</b>	<b>78.9</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Увс аймгийн ОНХС	1	5,915.1			1	5,915.1		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>5,915.1</b>			<b>1</b>	<b>5,915.1</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Увс аймгийн ОНХС	1	763.5			1	763.5		
Увс аймгийн ОНХС	1	6,547.9					1	6,547.9
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>7,311.4</b>			<b>1</b>	<b>763.5</b>	<b>1</b>	<b>6,547.9</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>13,226.5</b>			<b>2</b>	<b>6,678.6</b>	<b>1</b>	<b>6,547.9</b>

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Р.АЮУШ/

2026 оны 03 сарын 24-ний өдөр